



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2020





ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2020 ОНД

2021 он

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Вэб хаяг: www.nso.mn , www.1212.mn

Утас: 1900-1212

Танилцуулгыг бэлтгэсэн:

БХАГ-ын ҮТХ-ийн дарга Б.Баярмаа

БХАГ-ын ҮТХ-ийн статистикч Н.Лхам

Утас: 51-262767

Гарчиг

Товчилсон үгийн жагсаалт	2
Хүснэгтийн жагсаалт	3
Хавсралтын жагсаалт	3
Зургийн жагсаалт	3
1. ЭДИЙН ЗАСАГ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4
2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САЛБАРААР	6
3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕХНОЛОГИЙН БҮТЦЭЭР	6
4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР	7
4.1. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	8
4.2. ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	10
5. ХАВСРАЛТ ХҮСНЭГТ	12

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БРС	Бизнес регистрийн сан
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НХГХ	Нэмэгдүүлсэн хөрөнгө – гарцын харьцаа
ХАА	Хөдөө аж ахуй
ICOR	Incremental capital output ratio

Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 1. БРС-д бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, өмчийн хэлбэрээр
- Хүснэгт 2. Хөрөнгө оруулалт, түүний үр ашиг
- Хүснэгт 3. Хөрөнгө оруулалт, салбараар, тэрбум төгрөг
- Хүснэгт 4. Хөрөнгө оруулалт, технологийн бүтцээр, тэрбум төгрөг
- Хүснэгт 5. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрээр, тэрбум төгрөг
- Хүснэгт 6. Төсвийн хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг
- Хүснэгт 7. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, салбараар, 2020 он
- Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, салбар, бүсээр, 2020 он, тэрбум төгрөг
- Хүснэгт 9. ГШХО, орох урсгал, улсаар, сая америк доллар

Хавсралтын жагсаалт

- Хүснэгт 10.1. Нийт хөрөнгө оруулалт, салбараар, 2011-2020, тэрбум төгрөг
- Хүснэгт 10.2. ГШХО, салбараар, 2011-2020, тэрбум төгрөг
- Хүснэгт 10.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, бүс, аймаг, нийслэлээр, 2011-2020, тэрбум төгрөг
- Хүснэгт 10.4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бүс, аймаг, нийслэлээр, 2011-2020, тэрбум төгрөг


Зургийн жагсаалт

- Зураг 1. ДНБ, хөрөнгө оруулалтын өсөлт, бууралт
- Зураг 2. ДНБ (эцсийн ашиглалтын аргаарх)-ий бодит өсөлтөд бүрэлдэхүүн хэсгийн оролцоо, хувиар
- Зураг 3. Хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөж
- Зураг 4. Хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь
- Зураг 5. Төсвийн хөрөнгө оруулалтын бүтэц, салбараар
- Зураг 6. Төсвийн хөрөнгө оруулалтын бүтэц, зардлын төрлөөр
- Зураг 7. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, ДНБ-д эзлэх хувь
- Зураг 8. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, салбараар

1. ЭДИЙН ЗАСАГ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хөрөнгө оруулалт нь улс орны эдийн засгийн өсөлт, хөгжлийг санхүүжүүлэх механизмыг бий болгодог. Монгол Улсын эдийн засаг (ДНБ, 2015¹ оны зэрэгцүүлэх үнээр) 2018 онд 7.7 хувь, 2019 онд 5.6 хувиар өссөн ч Корона вируст цар тахлын нөлөөгөөр 2020 онд огцом буурч, эдийн засгийн өсөлт өмнөх онтой харьцуулахад 4.6 хувиар буурсан.

Зураг 1. ДНБ, хөрөнгө оруулалтын өсөлт, бууралт



Хөрөнгө оруулалтын хэмжээ (оны үнээр) 2012 он хүртэл тогтмол өссөн бөгөөд хууль эрх зүйн орчин, эдийн засгийн хямрал зэргээс шалтгаалан 2013-2015 онд мэдэгдэхүйц буурч, харин 2016-2019 онд өсөж, Корона вируст цар тахлын нөлөөгөөр 2020 онд өсөлтийн хурд саарсан байна.

Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулсан ААНБ-ын тоог өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2020 онд Монгол Улсын иргэний хувийн өмчийн ААНБ өмнөх оноос 0.1 хувь, төрийн болон орон нутгийн өмчийн ААНБ 1.3 хувиар нэмэгдэж, гадаад улсын өмчийн ААНБ 1.6 хувь, хувийн гадаадтай хамтарсан өмчийн ААНБ 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. БРС-д бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, өмчийн хэлбэрээр


Өмчийн хэлбэр	2017	2018	2019	2020	Дунд эзлэх хувь			
					2017	2018	2019	2020
Бүгд	78 597	85 761	94 425	94 491	100.0	100.0	100.0	100.0
Төрийн болон орон нутгийн өмчийн	4 992	4 949	5 060	5 128	6.4	5.8	5.4	5.4
Монгол Улсын иргэний хувийн	70 080	76 886	84 069	84 162	89.2	89.7	89.0	89.1
Хувийн гадаадтай хамтарсан	1 307	1 120	1 128	1 098	1.7	1.3	1.2	1.2
Гадаад улсын	2 218	2 806	4 168	4 103	2.8	3.3	4.4	4.3

Хөрөнгө оруулалт гэдэг нь ирээдүйд орлого, ашиг олох зорилгоор өнөөдөр зарцуулж буй хөрөнгө мөнгө юм. ДНБ-ий эцсийн ашиглалтын аргын бүрэлдэхүүний нэг болох хөрөнгийн нийт хуримтлалыг хөрөнгө оруулалтын мэдээлэлд үндэслэн тооцдог. Энэ нь эдийн засагт хөрөнгө оруулалтын зорилгоор шинээр бий болсон нэмэгдсэн өртгийг харуулдаг. Хөрөнгийн нийт хуримтлал нь үндсэн хөрөнгийн нийт хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлалаас бүрдэнэ.

Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал нь үндэсний тооцоонд хэрэглэгддэг макро эдийн засгийн ухагдахуун бөгөөд үндсэн хөрөнгийн цэвэр нэмэгдлийг (нэмэгдсэн хөрөнгөөс хасагдсан хөрөнгийг хасна) ойлгох ба энд *санхүүгийн хөрөнгө*, *эргэлтийн хөрөнгийн нөөц* болон бусад үйл ажиллагааны зардал орохгүй тул нийт хөрөнгө оруулалтаас ялгаатай.

Хөрөнгийн нийт хуримтлал 2018 онд ДНБ-ий өсөлтийн ихэнх хувийг хангаж байсан бол 2020 онд бууралтын ихэнх хувийг хангасан байна.

Зураг 2. ДНБ (эцсийн ашиглалтын аргаарх)-ий бодит өсөлтөд бүрэлдэхүүн хэсгийн оролцоо, хувиар



Хөрөнгө оруулалтын үр ашиг

Хөрөнгө оруулалт нь нэг талаар ирээдүйд ашиг олох зорилгоор өнөөдөр зарцуулж буй хөрөнгө, нөгөө талаар эдийн засгийн буюу ДНБ-ий өсөлтийг хангахад чиглэгддэг. Хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцох нэг арга нь **нэмэгдүүлсэн хөрөнгө – гарцын харьцаа (НХГХ)-ны арга** (Incremental Capital-Output Ratio, ICOR) гэж үздэг. Уг аргыг ашигласнаар **ДНБ-ий хэмжээг нэгжээр (төгрөгөөр) нэмэгдүүлэхийн тулд хичнээн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатайг** тодорхойлдог үзүүлэлт юм. Үүнийг томъёогоор илэрхийлбэл,

$$ICOR = \frac{\Delta K}{\Delta Y} = \frac{\Delta K/Y}{\Delta Y/Y} = \frac{I/Y}{\Delta Y/Y} = \frac{I}{\Delta Y}$$

ICOR - нэмэгдүүлсэн хөрөнгө – гарцын харьцааны арга

ΔK - нэмэгдүүлсэн хөрөнгө буюу хөрөнгийн өөрчлөлт

ΔY – гарц буюу ДНБ-ий өсөлтийн хэмжээ

I – хөрөнгө оруулалтын хэмжээ

Мөн хөрөнгө оруулалтын үр ашгийг НХГХ-ны урвуу хэмжигдэхүүн (1/ICOR)-ээр тодорхойлдог. Уг харьцаа нь **нэгж хөрөнгө оруулалтад ногдох ахиуц бүтээгдэхүүн** буюу нэмүү өртөг бүтээлтийн хэмжээг илэрхийлнэ.


- ✓ НХГХ (ICOR) – бага байвал хөрөнгө оруулалтын үр ашиг өндөр;
- ✓ 1/НХГХ (1/ICOR) – их байх тусам хөрөнгө оруулалтын үр ашиг их байгааг илэрхийлнэ.

Хүснэгт 2. Хөрөнгө оруулалт, түүний үр ашиг

Он	Хөрөнгө оруулалт ¹ , зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг	ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг	ДНБ-ий өөрчлөлт, тэрбум төгрөг	Хөрөнгө оруулалтын үр ашиг (НХГХ)	Хөрөнгө оруулалтын өгөөж (1/НХГХ)
A	1	2	3	4=1:3	5
2016	9 103.3	23 240.9	346.1	26.30	0.04
2017	10 192.9	24 533.7	1 292.9	7.88	0.13
2018	11 582.5	26 393.9	1 860.2	6.23	0.16
2019	13 383.2	27 836.8	1 442.9	9.28	0.11
2020	13 432.3	26 622.7	- 1 214.1	-11.06	-0.09

ДНБ-ий болон хөрөнгө оруулалтын өгөөжийн хандлага ойролцоо бөгөөд хөрөнгө оруулалтын үр ашиг 2016 онд хамгийн бага байж, 2017 оноос өсөж байснаа 2020 онд сөрөг утгатай байгаа нь Корона вируст цар тахлын нөлөөгөөр хөрөнгө оруулалтын өгөөж буурсан байна. Хөрөнгө оруулалтын үр ашиг өндөр байсан 2018 онд ДНБ-ийг 100 төгрөгөөр нэмэгдүүлэхэд 623 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бол хамгийн муу байсан 2016 онд 2630 төгрөгийн хөрөнгө оруулалт ногдож байна.

Зураг 3. Хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөж



¹Хөрөнгө оруулалтыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ хөрөнгийн нийт хуримтлалын 2015 оны суурьтай дефляторыг ашигласан болно.

2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САЛБАРААР

Хөрөнгө оруулалтын хэмжээ 2020 онд нийт дүнгээрээ 17.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 5.3 хувиар өссөн байна. Корона вируст цар тахлын нөлөөгөөр 2020 онд уул уурхай, олборлолтын салбарынх 1.2 их наяд төгрөг буюу 14.2 хувиар буурсан ч эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ 1.3 их наяд төгрөг буюу 7.6 дахин, үйлчилгээний бусад салбарынх 0.9 их наяд төгрөг буюу 2.3 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Хөрөнгө оруулалт, салбараар, тэрбум төгрөг

Салбар	2017	2018	2019	2020	<u>2019 %</u> 2018	<u>2020%</u> 2019
Бүгд	10 784.6	13 463.8	16 300.7	17 162.3	124.8	105.3
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	95.5	124.6	114.8	67.8	92.1	59.1
Уул уурхай, олборлох	4 954.2	6 191.9	8 486.3	7 285.2	137.1	85.8
Боловсруулах үйлдвэрлэл	193.5	1 120.8	580.0	395.4	51.8	68.2
Цахилгаан, хий, ус хангамж	597.5	970.1	525.6	1 096.4	54.2	208.6
Барилга	945.2	1 036.0	1 046.5	989.2	101.0	94.5
Бөөний болон жижиглэн худалдаа	863.7	682.7	908.8	1 001.4	133.1	110.2
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	217.7	281.7	522.8	316.5	185.6	60.5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	75.9	66.0	54.1	30.8	81.9	57.0
Мэдээлэл, холбоо	184.5	257.3	296.3	249.9	115.1	84.3
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	642.2	561.8	745.6	460.1	132.7	61.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	52.1	87.9	51.7	39.7	58.8	76.9
Төрийн удирдлага	1 073.5	915.2	1 295.8	1 634.8	141.6	126.2
Боловсрол	192.9	333.7	749.4	409.6	224.6	54.7
Эрүүл мэнд	423.0	226.8	200.8	1 518.4	88.5	756.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	273.2	607.2	722.2	1 667.2	118.9	230.8

Хөрөнгө оруулалтын хэмжээ 2019-2020 онд нэмэгдэхэд уул уурхай, олборлох салбар, эрүүл мэнд, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар дах хөрөнгө оруулалтын хэмжээ өссөн нь голлон нөлөөлсөн байна.

3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕХНОЛОГИЙН БҮТЦЭЭР

Нийт хөрөнгө оруулалтыг технологийн бүтцээр авч үзвэл, 2020 онд 27.4 хувийг барилга угсралтын ажил, 33.5 хувийг машин, тоног төхөөрөмж, 39.2 хувийг бусад хөрөнгө оруулалт эзэлж байгаа нь өмнөх оноос бусад хөрөнгө оруулалт 8.7 нэгж хувиар өсөж, машин, тоног төхөөрөмжид оруулсан хөрөнгө оруулалт 6.9 нэгж хувиар, барилга угсралтын ажилд оруулсан хөрөнгө оруулалт 1.8 нэгж хувиар тус тус буурчээ.

Хүснэгт 4. Хөрөнгө оруулалт, технологийн бүтцээр, тэрбум төгрөг

Бүрэлдэхүүн	2016	2017	2018	2019	2020	<u>2020%</u> 2019
Бүгд	8 940.6	10 784.6	13 463.8	16 300.7	17 162.3	105.3
Барилга угсралт	3 356.3	3 783.6	4 305.6	4 747.5	4 695.9	98.9
Орон сууцны барилга	1 179.3	1 314.8	1 436.8	1 329.7	1 347.6	101.3
Орон сууцны бус барилга	1 344.1	1 375.3	1 503.7	2 240.8	1 689.0	75.4
Инженерийн барилга, байгууламж	769.7	1 007.8	1 268.8	1 063.1	1 520.4	143.0
Их засварын ажил	63.2	85.7	96.2	113.9	138.9	122.0
Машин, тоног төхөөрөмж	2 400.7	3 912.9	5 650.5	6 587.0	5 744.9	87.2
Тээврийн хэрэгсэл	755.9	1 332.1	1 990.8	2 809.6	1 985.1	70.7
Бусад машин, тоног төхөөрөмж	1 644.8	2 580.8	3 659.6	3 777.4	3 759.8	99.5
Геологи хайгуулын ажил	160.5	93.1	160.4	305.4	51.2	16.8
Бусад	3 023.2	2 994.9	3 347.4	4 660.7	6 670.3	143.1

4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР

Хөрөнгө оруулалтыг санхүүжилтийн эх үүсвэрээр нь дотоод болон гадаад гэж ангилна. Дотоодын хөрөнгө оруулалтыг улсын төсөв, бусад (өөрийн болон банкны зээлийн хөрөнгө оруулалт), харин гадаадын хөрөнгө оруулалтыг гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж гэж ангилна.


Монгол Улс дотоодын хуримтлал бага тул нийт хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг гадаад эх үүсвэр бүрдүүлж байна. Тухайлбал, 2020 онд нийт хөрөнгө оруулалтын 63.2 хувийг гадаад эх үүсвэрээр бүрдүүлсэн байна.

Дэлхийн болон бүс нутгийн эдийн засагт Корона вируст цар тахлын үзүүлж буй сөрөг нөлөөллийн улмаас 2019 онтой харьцуулахад гадаадын шууд хөрөнгө оруулалт 12.2 хувиар, төсвийн хөрөнгө оруулалт 3.3 хувиар буурч, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хэмжээ 76.3-107.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрээр, тэрбум төгрөг

Эх үүсвэр	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
Бүгд	8 940.6	10 784.6	13 463.8	16 300.7	17 162.3	105.3
Дотоод	4 318.9	3 406.4	5 124.8	6 254.5	6 323.1	101.1
Улсын төсөв	1 443.5	1 051.4	1 071.2	2 028.5	1 961.4	96.7
Бусад	2 875.4	2 355.0	4 053.5	4 226.1	4 361.7	103.2
Гадаад	4 621.8	7 378.2	8 339.1	10 046.1	10 839.2	107.9
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	3 192.4	5 091.8	6 747.1	8 339.0	7 320.5	87.8
Хөнгөлөлттэй зээл	1 350.1	2 229.6	1 490.5	1 621.9	3 368.4	207.7
Буцалтгүй тусламж	79.3	56.8	101.5	85.2	150.3	176.3

Зураг 4. Хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь



Хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь 2011-2012 онд 63.0-76.7 хувь байсан бол 2014-2015 онд 31.1-38.6 хувь болж буурсан байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь 2010-2013 онд дотоодын хөрөнгө оруулалтынхаас өндөр байсан бол 2014-2015 онд дотоодын хөрөнгө оруулалт давамгайлж, харин 2016 оноос эргээд гадаадын хөрөнгө оруулалт давамгайлж эхэлсэн байна.

4.1. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Төсвийн хөрөнгө оруулалт 2020 онд 2.0 их наяд төгрөг болж, үүний 72.1 хувийг улсын төсвөөр, 27.9 хувийг орон нутгийн төсвөөр бүрдүүлжээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалт өмнөх оноос 145.4 тэрбум төгрөг буюу 9.3 хувиар буурч, харин орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 78.3 тэрбум төгрөг буюу 16.7 хувиар өссөн.

Хүснэгт 6. Төсвийн хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг

	2016	2017	2018	2019	2020	Бүтэц				
						2016	2017	2018	2019	2020
Төсвийн хөрөнгө оруулалт – бүгд	1 443.5	1 051.4	1 071.2	2 028.5	1 961.4	100.0	100.0	100.0	100.0	100.0
Улсын төсвийн	976.6	715.7	659.2	1 559.9	1 414.6	67.7	68.1	61.5	76.9	72.1
Орон нутгийн төсвийн	464.0	335.7	412.0	468.5	546.8	32.1	31.9	38.5	23.1	27.9

Төсвийн хөрөнгө оруулалтыг үйл ажиллагааны салбараар авч үзвэл, 2020 онд барилгын салбарт 27.3 хувь нь, төрийн удирдлагын салбарт 26.4 хувь нь, боловсролын салбарт 17.5 хувь нь, цахилгаан, хий, уур, усан хангамжийн салбарт 7.6 хувь нь, эрүүл мэндийн салбарт 5.8 хувь нь ногдож байна. Өмнөх онтой харьцуулахад барилгын салбарт өсөлт гарчээ.

Зураг 5. Төсвийн хөрөнгө оруулалтын бүтэц, салбараар, 2020 он



Төсвийн хөрөнгө оруулалт 2020 оны гүйцэтгэлээр, **улсын төсвийн хөрөнгө оруулалтын** 36.1 хувь нь барилгын салбарт, 18.9 хувь нь төрийн удирдлагын салбарт, 18.1 хувь нь боловсролын салбарт, 8.8 хувь нь цахилгаан, хий, уур, агааржуулалт, усан хангамжийн салбарт ногдож байхад **орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын** 45.7 хувь нь төрийн удирдлагын салбарт, 16.0 хувь нь боловсролын салбарт, 5.5 хувь нь эрүүл мэндийн салбарт, 4.5 хувь нь барилгын салбарт ногдож байна.

Хүснэгт 7. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, салбараар, 2020 он

Салбар	Улсын төсөв		Орон нутгийн төсөв	
	Дүн, тэрбум төгрөг	Бүтэц, %	Дүн, тэрбум төгрөг	Бүтэц, %
Бүгд	1 414.6	100.0	546.8	100.0
Хөдөө аж ахуй	0.0	0.0	6.2	1.1
Үйлдвэрлэл	636.3	45.0	48.7	8.9
Үйлчилгээ	778.3	55.0	491.9	90.0
Тээвэр, холбоо	21.5	1.5	0.6	0.1
Төрийн удирдлага	266.8	18.9	250.1	45.7
Боловсрол	255.7	18.1	87.2	16.0
Эрүүл мэнд	84.0	5.9	30.0	5.5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	150.3	10.6	124.0	22.7

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг бүсээр авч үзвэл, нийт хөрөнгө оруулалтын 49.2 хувь нь Улаанбаатарт, 26.9 хувь нь төвийн бүсэд, 10.0 хувь нь хангайн бүсэд, 8.0 хувь нь баруун бүсэд, 5.9 хувь нь зүүн бүсэд тус тус ногдож байна.

Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, салбар, бүсээр, 2020 он, тэрбум төгрөг


Салбар	Улсын дүн	Бүс				
		Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар
Бүгд	546.8	43.9	54.5	147.2	32.3	268.9
Хөдөө аж ахуй	6.2	2.2	0.7	0.9	1.1	1.2
Үйлдвэрлэл	48.7	4.3	1.8	22.8	9.1	10.7
Үйлчилгээ	491.9	37.3	52.0	123.5	22.1	257.0
Тээвэр, холбоо	0.6	0.6	-	-	0.0	0.0
Төрийн удирдлага	250.1	15.5	38.7	19.0	6.1	170.8
Боловсрол	87.2	6.6	7.1	24.6	12.3	36.6
Эрүүл мэнд	30.0	1.5	1.6	7.2	2.2	17.5
Үйлчилгээний бусад	124.0	13.2	4.6	72.7	1.4	32.1

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 90 хувь нь үйлчилгээний салбарт ногдож байна. Хангайн болон Зүүн бүс, Улаанбаатарт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 35-71 хувь нь төрийн удирдлагын салбарт, Зүүн бүсэд 38 хувь нь боловсролын салбарт, Хангайн болон Төвийн бүсийн орон нутгийн хөрөнгө оруулалтын 30- 49 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт ногдож байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын бүтэц

Төсвийн хөрөнгө оруулалтыг зардлын бүтцээр нь авч үзвэл, 2020 онд 70.7 хувийг барилга, байгууламжийн зардалд, 14.5 хувийг бусад зардалд, 8.4 хувийг тоног төхөөрөмжийн зардалд, 6.5 хувийг их засварын зардалд хөрөнгө оруулсан байна.

Зураг 6. Төсвийн хөрөнгө оруулалтын бүтэц, зардлын төрлөөр




4.2. ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсад 2000-2020 онд нийтдээ 61.5 их наяд төгрөгийн гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээ жил жилд тогтворгүй байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) 2020 онд 7.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.0 их наяд төгрөгөөр буюу 12.2 хувиар буурсан байна.

Зураг 7. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, ДНБ-д эзлэх хувь



Уул уурхайн томоохон бүтээн байгуулалт эхэлсэнтэй холбогдуулан 2011, 2012 онд томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын урсгал орж ирсэн бөгөөд улс төрийн тогтворгүй байдал, дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас шалтгаалан ГШХО буурч байсан ч 2016 оноос эргэн сэргэж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг голлох улсаар нь авч үзвэл, 2020 онд Канад улс 1373.0 (53.6%) сая америк доллар, Австрали 313.7 (12.3%) сая америк доллар, БНХАУ 263.2 (10.3%) сая америк доллар, Сингапур 155.4 (6.1%) сая америк доллар, АНУ 128.5 (5.0%) сая америк долларын хөрөнгө оруулалтыг тус тус хийжээ.

Хүснэгт 9. ГШХО, орох урсгал, улсаар, сая америк доллар²

Улс	2016	2017	2018	2019	2020	<u>2020</u> 2019%
Бүгд	1 486.4	2 086.3	2 728.7	3 130.8	2 560.2	81.8
Канад	531.1	766.3	1 647.5	1 886.7	1 373.0	72.8
Австрали	20.6	43.1	15.6	20.0	313.7	15.7*
БНХАУ	247.0	223.9	357.7	314.8	263.2	83.6
Сингапур	73.2	135.1	54.7	155.8	155.4	99.8
АНУ	90.2	138.9	78.0	87.6	128.5	146.6
Япон	94.3	91.8	243.7	121.7	98.9	81.3
Их Британи	33.0	25.1	19.3	74.5	51.9	69.6
Люксембург	59.1	247.0	64.2	127.5	37.4	29.3
Хонг-Конг	227.3	101.9	78.8	169.9	25.7	15.1
Малайз	0.1	0.4	0.3	0.5	17.2	35.1*
Белги	0.8	24.9	1.4	13.2	16.4	123.8
Кайманы арлууд	3.9	10.9	50.8	0.3	15.4	57.8*
Нидерланд	10.8	68.3	4.2	6.2	13.1	2.1*
Франц	13.5	9.0	15.0	13.4	12.8	95.7
БНСУ	27.5	10.2	27.0	21.8	11.5	52.6
Бусад	54.3	189.6	70.6	116.8	26.3	22.5

*- Дахин их

² https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=4_2

Зураг 8. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, салбараар, 2020 он



Монгол Улсад 2020 онд орсон ГШХО-ыг салбараар авч үзвэл, уул уурхай, олборлох салбарт 4799.9 (65.6%) тэрбум төгрөг, бөөний болон жижиглэн худалдааны салбар 640.2 (8.7%) тэрбум төгрөг, санхүү, даатгалын салбарт 315.9 (4.3%) тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Дүгнэлт

Улс орны эдийн засгийн өсөлт, хөгжлийг санхүүжүүлэх механизмыг бий болгодог хөрөнгө оруулалт нь 2017-2019 онд тогтвортой 21-24 хувийн өсөлттэй байсан хэдий ч Корона вируст цар тахлын нөлөөгөөр 2020 онд огцом саарч, хөрөнгө оруулалтын өсөлт өмнөх онтой харьцуулахад 5.3 хувиар өслөө.

Корона вирусын дэгдэлттэй холбоотой 2020 онд ДЭМБ-аас онц байдал зарласнаар олон улсын нислэгүүд цуцлагдаж, мөн дотооддоо хөл хорио тогтоож, зарим салбарын үйл ажиллагааг үе шаттайгаар зогсоох хүртэл арга хэмжээ авсан.

Дэлхийн болон бүс нутгийн эдийн засагт Корона вируст цар тахлын үзүүлж буй сөрөг нөлөөллийн улмаас 2019 онтой харьцуулахад гадаадын шууд хөрөнгө оруулалт 12.2 хувиар, төсвийн хөрөнгө оруулалт 3.3 хувиар буурч, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хэмжээ 76.3-107.7 хувиар өссөн байна.

Корона вируст цар тахлын нөлөөгөөр 2020 онд уул уурхай, олборлолтын салбарынх 1.2 их наяд төгрөг буюу 14.2 хувиар буурсан ч эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ 1.3 их наяд төгрөг буюу 7.6 дахин, үйлчилгээний бусад салбарынх 0.9 их наяд төгрөг буюу 2.3 дахин нэмэгдсэн байна.

5. ХАВСРАЛТ ХҮСНЭГТ

Хүснэгт 10.1. Нийт хөрөнгө оруулалт, салбараар, 2011-2020, тэрбум төгрөг

Салбар	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Бүгд	10 104.6	10 516.2	8 329.4	8 590.3	7 114.1	8 940.6	10 784.6	13 463.8	16 300.7	17 162.3
Хөдөө аж ахуй ойн аж ахуй, загас барилт	48.1	71.4	54.0	106.9	144.9	85.7	95.5	124.6	114.8	67.8
Уул уурхай, олборлох	6 159.4	5 856.8	4 526.3	3 229.5	2 931.1	3 212.8	4 954.2	6 191.9	8 486.3	7 285.2
Боловсруулах үйлдвэрлэл	161.4	184.3	296.0	470.7	386.7	498.6	193.5	1 120.8	580.0	395.4
Цахилгаан, хий, ус хангамж	215.5	181.5	204.9	312.6	317.9	388.5	597.5	970.1	525.6	1 096.4
Барилга	886.8	1 046.1	923.6	1 013.0	845.8	1 488.3	945.2	1 036.0	1 046.5	989.2
Бөөний болон жижиглэн худалдаа	952.3	1 097.7	669.5	894.0	342.6	388.5	863.7	682.7	908.8	1 001.4
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	240.9	264.0	213.0	371.6	74.5	151.3	217.7	281.7	522.8	316.5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	64.9	110.2	24.9	82.0	374.2	600.2	75.9	66.0	54.1	30.8
Мэдээлэл, холбоо	82.3	181.6	181.8	254.8	233.3	191.8	184.5	257.3	296.3	249.9
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	240.1	286.3	213.5	412.6	173.6	168.9	642.2	561.8	745.6	460.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	85.1	91.6	184.1	138.6	45.4	155.2	52.1	87.9	51.7	39.7
Төрийн удирдлага	373.6	429.1	401.8	427.2	380.3	754.1	1 073.5	915.2	1 295.8	1 634.8
Боловсрол	146.0	120.9	121.7	359.7	229.1	231.5	192.9	333.7	749.4	409.6
Эрүүл мэнд	30.5	42.7	56.3	197.1	330.0	259.7	423.0	226.8	200.8	1 518.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	417.6	552.2	257.9	319.9	304.9	365.4	273.2	607.2	722.2	1 667.2

Хүснэгт 10.2. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, салбараар, 2011-2020, тэрбум төгрөг

Салбар	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Бүгд	7 270.8	7 112.4	4 952.6	3 621.0	2 751.7	3 192.4	5 091.8	6 747.1	8 339.0	7 320.5
Хөдөө аж ахуй ойн аж ахуй, загас барилт	10.3	7.6	5.7	21.0	8.2	11.3	13.5	8.4	8.6	3.7
Уул уурхай, олборлох	5 685.0	5 316.9	3 825.1	2 312.2	1 556.3	2 021.4	3 520.3	5 267.6	6 324.4	4 799.9
Боловсруулах үйлдвэрлэл	71.0	86.0	68.0	52.9	59.0	51.7	80.7	107.2	70.9	26.5
Цахилгаан, хий, ус хангамж	8.5	9.9	5.5	2.0	2.4	4.1	61.2	3.6	3.0	30.3
Барилга	118.2	221.5	145.6	225.5	149.8	151.5	135.3	53.6	140.3	92.7
Бөөний болон жижиглэн худалдаа	826.5	931.9	483.1	532.1	200.1	239.5	725.2	354.2	695.1	640.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	16.3	6.5	7.0	14.8	12.3	14.3	100.5	4.1	78.2	108.6
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	34.4	90.1	7.2	8.7	336.7	311.2	57.3	25.1	36.0	0.5
Мэдээлэл, холбоо	46.2	26.3	13.1	35.3	60.5	22.6	11.7	18.7	16.6	17.0
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	179.6	170.2	184.2	213.5	141.9	156.7	130.8	554.9	512.1	315.9
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	76.6	52.3	43.7	32.8	28.5	48.5	50.9	51.5	42.6	33.9
Төрийн удирдлага	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	3.4	0.0	0.0
Боловсрол	5.8	0.2	0.4	0.7	0.0	2.0	1.5	1.5	5.1	0.5
Эрүүл мэнд	1.0	1.2	0.9	1.1	1.3	3.6	49.4	2.9	1.9	0.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	191.4	191.7	163.2	168.3	194.8	153.9	153.6	290.3	404.0	1 250.5

Хүснэгт 10.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, бүс, аймаг, нийслэлээр, 2011-2020, тэрбум төгрөг

Аймаг, нийслэл	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Бүгд	931.4	1 180.0	831.8	1 000.5	704.6	976.6	715.7	659.2	1 559.9	1 414.6
Баруун бүс	92.2	153.5	83.7	119.4	95.1	70.7	181.5	190.0	319.2	478.4
Баян-Өлгий	7.7	21.1	15.5	17.4	5.2	5.9	4.6	18.5	37.9	28.3
Говь-Алтай	31.6	13.3	3.9	12.5	6.6	12.2	139.0	95.3	108.5	118.3
Завхан	14.7	16.7	23.1	28.2	40.5	13.1	14.0	21.8	49.2	102.6
Увс	22.2	31.7	12.5	17.4	16.5	9.7	12.6	22.3	62.5	190.4
Ховд	16.1	70.7	28.7	43.9	26.3	29.8	11.4	32.1	61.1	38.8
Хангайн бүс	91.8	174.1	103.0	143.1	64.0	67.7	54.5	113.0	298.2	212.5
Архангай	7.0	8.0	16.6	33.9	10.8	11.7	6.9	15.8	48.2	45.8
Баянхонгор	11.5	80.7	10.5	13.4	7.6	13.2	8.9	20.5	51.8	39.9
Булган	3.3	7.0	11.2	18.7	8.8	6.6	4.5	12.2	28.6	34.9
Орхон	7.3	12.2	13.1	16.3	4.9	9.8	10.2	17.6	42.6	18.7
Өвөрхангай	19.7	24.4	24.5	21.5	17.1	4.7	8.5	23.1	58.1	35.8
Хөвсгөл	43.0	41.9	27.0	39.3	14.9	21.7	15.5	23.8	68.9	37.4
Төвийн бүс	37.2	96.3	116.5	190.8	91.4	529.2	83.3	116.9	313.4	248.4
Говьсүмбэр	1.2	1.7	3.2	4.8	0.9	1.5	3.1	6.4	61.9	47.9
Дархан-Уул	16.1	27.9	21.2	40.3	27.2	11.9	16.2	22.2	49.3	33.2
Дорноговь	1.8	2.6	26.9	21.9	15.1	10.1	18.4	13.0	45.0	37.2
Дундговь	3.7	2.8	6.4	18.4	7.6	4.7	3.6	15.7	31.4	14.6
Өмнөговь	3.3	12.6	16.4	40.8	15.4	212.5	5.4	14.5	34.5	30.9
Сэлэнгэ	3.8	40.3	14.1	30.3	9.6	279.2	11.8	16.7	48.3	43.5
Төв	7.1	8.5	28.3	34.3	15.6	9.3	24.8	28.5	43.0	41.1
Зүүн бүс	21.8	30.2	52.0	75.5	41.0	75.7	28.5	48.0	124.8	126.4
Дорнод	5.5	7.3	18.4	25.9	19.9	11.1	8.2	15.7	36.2	25.5
Сүхбаатар	9.6	18.5	14.6	24.9	10.0	6.7	8.5	10.9	30.9	18.5
Хэнтий	6.6	4.4	19.0	24.7	11.2	57.8	11.8	21.4	57.7	82.4
Улаанбаатар	688.4	725.9	476.6	471.6	413.0	233.3	367.9	191.2	504.3	349.0

Хүснэгт 10.4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бүс, аймаг, нийслэлээр, 2011-2020, тэрбум төгрөг

Аймаг, нийслэл	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Бүгд	176.8	246.0	399.6	508.2	429.8	464.0	334.4	412.0	468.5	546.8
Баруун бүс	5.9	8.1	29.3	46.8	45.7	23.0	10.0	25.7	46.0	43.9
Баян-Өлгий	1.0	1.2	6.9	7.6	2.3	4.0	2.6	7.2	7.1	5.4
Говь-Алтай	1.5	3.1	5.8	12.7	21.1	6.4	2.7	4.5	8.5	5.2
Завхан	0.9	1.3	0.8	8.4	2.2	4.5	2.3	5.9	5.7	6.2
Увс	1.5	1.3	7.5	8.7	17.3	4.3	0.9	4.2	15.8	15.4
Ховд	1.0	1.2	8.3	9.4	2.9	3.7	1.7	4.0	8.9	11.7
Хангайн бүс	12.1	14.9	28.3	71.9	59.0	55.5	91.3	47.6	52.7	54.5
Архангай	0.8	1.4	6.2	7.8	6.4	3.8	14.8	6.2	5.2	5.1
Баянхонгор	1.1	0.9	0.4	0.4	2.5	1.3	1.6	5.1	6.6	6.9
Булган	0.7	0.8	3.3	8.5	14.6	9.2	3.8	4.8	1.8	1.3
Орхон	6.0	7.1	8.9	29.2	23.6	30.2	30.9	15.2	20.9	24.6
Өвөрхангай	1.6	2.0	1.4	13.7	6.6	6.4	4.4	8.3	9.0	7.6
Хөвсгөл	1.9	2.5	8.1	12.2	5.2	4.6	35.8	8.0	9.3	9.1
Төвийн бүс	38.5	38.0	78.6	133.5	83.8	80.6	62.4	89.0	123.9	147.2
Говьсүмбэр	1.3	1.4	5.7	6.5	2.7	2.5	1.8	1.4	1.5	2.3
Дархан-Уул	2.3	2.3	7.9	9.5	4.6	6.7	5.8	8.4	10.1	10.7
Дорноговь	5.1	4.7	10.5	10.7	2.3	7.4	7.3	11.4	15.6	21.9
Дундговь	1.0	1.3	5.4	9.2	22.9	5.6	3.2	3.4	3.2	2.9
Өмнөговь	24.2	20.6	32.2	88.0	37.8	47.2	33.8	48.4	77.6	89.2
Сэлэнгэ	3.6	5.7	8.4	9.0	2.7	6.2	5.0	7.8	7.2	8.7
Төв	1.0	2.0	8.5	0.5	10.9	5.1	5.6	8.1	8.7	11.5
Зүүн бүс	5.7	8.6	17.5	40.4	12.6	20.1	7.3	13.2	21.6	32.3
Дорнод	1.6	2.2	6.9	11.5	3.4	6.1	2.7	7.9	11.0	13.6
Сүхбаатар	2.9	4.2	0.9	17.2	5.8	8.3	2.2	1.9	4.8	11.3
Хэнтий	1.2	2.2	9.7	11.7	3.3	5.6	2.5	3.4	5.8	7.4
Улаанбаатар	114.5	176.5	245.9	215.6	228.8	284.7	163.3	236.5	224.3	268.9